



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 6, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны цахилгаан станц-4” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 4,340.15 (дөрвөн тэрбум гурван зуун дөчин сая нэг зуун тавин мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулааны цахилгаан станц-4” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дулааны цахилгаан станц-4” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Анхбаярт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргаж ажилласан үнэлгээний хорооны гишүүд болон холбогдох ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох;

2.3. Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, харилцагчтай үлдэгдэл төлбөр тооцоог нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.4. Инженерийн барилга байгууламжийн ашиглалтын цэвэрлэгээ, засвар үйлчилгээг өөрийн дотоод нөөц бололцоогоор зохион байгуулах ажлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 13 дугаар тогтоолыг үндэслэн турбин агрегат-7 тоноглолыг нягтлан бодох бүртгэлийн стандартын 20 дахь хэсэгт заасны дагуу орлогын аргаар бүртгэж, бууруулсан хөрөнгийн дүнгээр 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах бичилт хийх;

2.6. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах,

биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 22 дугаар сарын 27-ний өдрийн  
 30... дугаар тогтоолын хавсралт



“Дулааны цахилгаан станц-4” төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Дүн /сая төгрөг/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө олж авсан	Гүйцэтгэх захирал, Эдийн засаг, санхүүгийн алба	381.8	Эрх бүхий байгууллагаас хуулийн дагуу үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл авах
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7, 8, 12, 14, 27, 29, 32 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Үнэлгээний хорооны гишүүд, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Судалгаа хөгжлийн алба	3,958.35	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах
<b>Зөрчил, дутагдлын нийт дүн</b>			<b>4,340.15</b>	